



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.08.12 № 37-1/106
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244002797



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.08.12 № ХЭГ/1462
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ^{26/} хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:

“7.ХЭЛЭЛЦСЭН нь:

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.08.03 № **01/6692**

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761002091



САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 08. 09 № 1/245
танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсэгт зааснаар тус хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ



САНГИЙН САЙД Б. ЖАВХЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2024. 08. 09 № 01/1513

танай _____-ны № _____-т

Зөвшөөрөл олгох тухай

Танаас 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр ирүүлсэн 01/6624 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төсвийн тусгай шаардлагад хамрагдах төсвийн тэнцэл болох нэгдсэн төсвийн суурь тэнцлийг тооцоход үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг оруулахгүй байх зохицуулалтыг тусгасан байгаа нь цаашид төсвийн хөрөнгийн зардал огцом нэмэгдэж төсвийн сахилга бат алдагдах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо буурч, төрийн оролцоо нэмэгдэх, Засгийн газар болон орон нутгийн төсвийн захирагч нар хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэх зорилгоор хэт их үнэт цаас гаргаж санхүүгийн зах зээлийн тэнцвэр алдагдах, улмаар макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлийг бий болгож байна.

Түүнчлэн нэгдсэн төсвийн урсгал зардлын дээд хэмжээг нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувь хүртэл нэмэгдүүлж болох заалтыг хуулийн төсөлд тусгасан байгаа нь цаашид төсвийн урсгал зардал хурдтай нэмэгдэх, уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл болон эдийн засгийн мөчлөгийг дагасан төсвийн бодлого хэрэгжих нөхцөлийг бүрдүүлснээр макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдаж, улсын зээлжих зэрэглэл буурах эрсдэл үүсэхээр байгааг анхаарна уу.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголын төсөлд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа тул Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтын дагуу зөвшөөрөл олгож байна.



Л.ГАНТӨМӨР

240148

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН
ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026
ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ
2024 он



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогц байхаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг байхаар, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхээр тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжил, Шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гадаад зээл, тусламжийн төслүүдийг хугацаанд нь дуусгаж ашиглалтад оруулах, төслүүдийн үр ашиг, үр дүнг хангах үүднээс гадаад зээл, тусламжийн төслүүдийг эрэмбэлж, ач холбогдол өндөр төслүүдийн ашиглалтыг ирэх жилүүдэд нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага бий болсон.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, нийслэлийн дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн томоохон бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гадаад зээл, тусламжийн төслүүдийг хугацаанд нь дуусгаж ашиглалтад оруулах, төслүүдийн үр ашиг, үр дүнг хангах үүднээс гадаад зээл, тусламжийн төслүүдийг эрэмбэлж, ач холбогдол өндөр төслүүдийн ашиглалтыг ирэх жилүүдэд нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх юм.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.



ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болох сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдаж, улс төрийн намуудад ард түмний дэмжлэг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн Хамтарсан Засгийн газар байгуулагдаж, “Хурдтай Хөгжлийн Төлөөх Зориг” үнэт зүйлд нэгдэж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлж байна.

Энэ хүрээнд 3 намын мөрийн хөтөлбөрт туссан нийтлэг зорилгод суурилсан “ХУРДТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” Хамтарсан Засгийн газрын гэрээ байгуулагдаж, хамтын ажиллагааны зарчим, хүрээ, тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон. Уг гэрээнд үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, сорилтыг шийдвэрлэх, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага үүссэн.

Дараагийн 30 жилийн энэхүү хөгжлийн шинэ загварт нийцсэн төсвийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хадгалах төсвийн шинэчлэлийг эхлүүлж байна.

Монгол Улс анх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг уул уурхайн салбарын эрчимтэй өсөлтийн эхэн үе болох 2010 онд баталж, 2013 оноос хэрэгжүүлж эхэлснээр, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангах төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагууд үйлчилж эхэлсэн. Уг хуулийн гол зорилго нь эдийн засгийг уул уурхайн мөчлөг дагасан савлагаанаас хамгаалж, төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ба төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн зарчмаар тооцож, тодорхой хэсгийг төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах, төсвийн зарлагын өсөлтийг уул уурхайн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөр хязгаарлах, нэгдсэн төсвийн тэнцэл, Засгийн газрын өрийн хязгаарыг тогтоох замаар хэрэгжүүлж ирлээ.

Тухайн үед буюу 2013 онд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 19.2 их наяд төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 5.9 их наяд төгрөг, гадаад худалдааны нийт эргэлт 6.1 тэрбум ам.доллар байсан бол 2023 оны эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 3.7 дахин өсөж 70.4 их наяд төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3.9 дахин өсөж 23.3 их наяд төгрөг, гадаад худалдааны нийт эргэлт 2.3 дахин өсөж 24.4 тэрбум ам.долларт хүрч эдийн засгийн багтаамж 2-3 дахин тэлснийг харуулж байна. Мөн дахин сэргээгдэхгүй уул уурхайн баялгаас орж

ирэх орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах Ирээдүйн өв санд 3.4 их наяд төгрөг, уул уурхайн үнийн хэлбэлзлээс хамгаалж, төсвийг тогтворжуулах зорилготой Тогтворжуулалтын санд 1.3 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагууд төсвийн тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд түүхэн үүргээ гүйцэтгэснийг харуулж байна.

Дэлхий дахинд 2022 оны байдлаар 106 улс төсвийн тодорхой дүрэмтэй бөгөөд эдгээр улс орнууд хөгжлийн үе шатандаа нийцүүлэн эдийн засгийн өсөлтийг дэмжих томоохон төслүүд хэрэгжүүлэх, урсгал захиргааны зардлын өсөлтийг хязгаарлах төсвийн төлөвийг бодитой үнэлэх зэрэг нийтлэг шалтгаанаар төсвийн дүрмээ шинэчилдэг туршлага байна. Тухайлбал, Япон улс 1997 оноос төсвийн зарлага, алдагдлын хэмжээг хязгаарлаж эхэлснээс хойш 2001, 2023 онуудад эдийн засгийн өсөлтөө дэмжих, хүн ам зүйн асуудал, урт хугацаат өрийн асуудлаа шийдвэрлэх зорилгоор төсвийн дүрмээ шинэчилж байжээ. Их Британийн тухайд 1998 оноос “Алтан дүрэм”-ийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2010, 2014, 2019 онуудад төсвийн дүрэмдээ томоохон өөрчлөлтүүдийг хийж ирсэн нь хөгжлийг дэмжих дэд бүтцийн томоохон хөрөнгө оруулалт, төслүүдийг хэрэгжүүлэхэд уян хатан болгосны зэрэгцээ захиргааны урсгал зардалдаа илүү хяналт тавих боломжийг олгож байв. (Эх сурвалж: ОУВС, Улсуудын Сангийн яам)

Иймд Монгол Улсын дараагийн 30 жилийн хөгжлийн шинэ загварт тохирсон, дунд, урт хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хангах зорилтод нийцсэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг боловсронгуй болгон өргөн барьж байна.

Тогтвортой байдлын тухай хуульд туссан голлох зарчмын өөрчлөлтийг авч үзвэл:

- **Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг ДНБ-ийн 30 хувиас хэтрүүлэхгүй байх:** байнгын шинжтэй, тогтмол гардаг төсвийн урсгал зардлыг эдийн засгийн багтаамжийн тодорхой хувиар хязгаарласнаар төсвийн эдийн засаг дахь оролцоог хязгаарлах, хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх төсвийн орон зай үүсэх нөхцөл бүрдэх юм;
- **Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг ДНБ-ийн 2 хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх:** Дотоод эдийн засгийн нөөц сууриас бүрдсэн тэнцвэржүүлсэн орлогын эх үүсвэрээр төсвийн зардлыг хязгаарлаж, суурь тэнцлийн ашгийг тооцох ба уг эх үүсвэрээр өрийн үндсэн төлбөрийг төлөхөд зарцуулна. Ингэснээр ирээдүйд өрийн дарамтад орох эрсдэлээс сэргийлнэ;
- **Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр тооцох:** Дэлхий дахинд Засгийн газрын өрийн хязгаарыг мөрддөг 72 улс байгаагаас 65 улс нь нэрлэсэн үлдэгдлээр тооцож байна. Монгол Улс эдгээр орнуудын нийтлэг аргачлалд

шилжсэнээр харьцуулах боломж нэмэгдэхийн зэрэгцээ олон нийгэд ойлгомжтой болж, хяналт тавихад хялбар болох юм.

Дээрх өөрчлөлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай хуульд оруулснаар бид шинэ 30 жилийн хөгжлийг эхлүүлэх томоохон төслүүдийг гадаадын зээл, тусламж, үнэт цаас, төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн секторын эх үүсвэрээр хэрэгжүүлж, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Шинэ сэргэлтийн бодлогод туссан зорилтуудад хүрнэ.

Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг боловсронгуй болгосонтой холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт туссан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийг өөрчлөн найрууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 28,872.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 36.4 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 30,487.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.5 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -1,615.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн алдагдалтай, нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээг 27,269.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.4 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,603.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байх, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн хэмжээг 47,529.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 60 хувьтай тэнцэхээр тооцлоо.

Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн зүйл тус бүрээр:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

Дээр дурдсан шаардлагад үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн шинэчилсэн үзүүлэлтийг хүснэгтээр тусгасан.

---o0o---



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Монгол улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн
хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болох сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдаж, улс төрийн намуудад ард түмний дэмжлэг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн Хамтарсан Засгийн газар байгуулагдаж, “Хурдтай Хөгжлийн Төлөөх Зориг” үнэт зүйлд нэгдэж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлж байна.

Энэ хүрээнд 3 намын мөрийн хөтөлбөрт туссан нийтлэг зорилтод суурилсан “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” Хамтарсан Засгийн газрын гэрээ байгуулагдаж, хамтын ажиллагааны зарчим, хүрээ, тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон. Уг гэрээнд үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, сорилтыг шийдвэрлэх, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага үүссэн.

Дараагийн 30 жилийн энэхүү хөгжлийн шинэ загварт нийцсэн төсвийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хадгалах төсвийн шинэчлэлийг эхлүүлж байна.

Дэлхий дахинд 2022 оны байдлаар 106 улс төсвийн тодорхой дүрэмтэй бөгөөд эдгээр улс орнууд хөгжлийн үе шатандаа нийцүүлэн эдийн засгийн өсөлтийг дэмжих томоохон төслүүд хэрэгжүүлэх, урсгал захиргааны зардлын өсөлтийг хязгаарлах төсвийн төлөвийг бодитой үнэлэх зэрэг нийтлэг шалтгаанаар төсвийн дүрмээ шинэчилдэг туршлага байна. Тухайлбал, Япон улс 1997 оноос төсвийн зарлага, алдагдлын хэмжээг хязгаарлаж эхэлснээс хойш 2001, 2023 онуудад эдийн засгийн өсөлтөө дэмжих, хүн ам зүйн асуудал, урт хугацаат өрийн асуудлаа шийдвэрлэх зорилгоор төсвийн дүрмээ шинэчилж байжээ. Их Британийн тухайд 1998 оноос “Алтан дүрэм”-ийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2010, 2014, 2019 онуудад төсвийн дүрэмдээ томоохон өөрчлөлтүүдийг хийж ирсэн нь хөгжлийг дэмжих дэд бүтцийн томоохон хөрөнгө оруулалт, төслүүдийг хэрэгжүүлэхэд уян хатан болгосны зэрэгцээ захиргааны урсгал зардалдаа илүү хяналт тавих боломжийг олгож байв. (Эх сурвалж: ОУВС, Улсуудын Сангийн яам)

Иймд Монгол Улсын дараагийн 30 жилийн хөгжлийн шинэ загварт тохирсон, дунд, урт хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хангах зорилтод нийцсэн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг боловсронгуй болгон өргөн барьж байна.

Тус өөрчлөлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай хуульд оруулснаар бид шинэ 30 жилийн хөгжлийг эхлүүлэх томоохон төслүүдийг гадаадын зээл, тусламж, үнэт цаас, төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн секторын эх үүсвэрээр хэрэгжүүлж, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Шинэ сэргэлтийн бодлогод туссан зорилтуудад хүрнэ.

Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг боловсронгуй болгосонтой холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт туссан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийг өөрчлөн найрууллаа.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар сарын ... -ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2024 он	2025 он	2026 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.6	8.0	6.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.5	7.9	4.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	28,872.5	30,001.3	32,873.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	36.4	31.6	31.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	30,487.9	32,992.0	35,849.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	38.5	34.7	34.2
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,615.4	-2,990.7	-2,975.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-3.1	-2.8
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	27,269.0	28,101.0	30,779.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	34.4	29.6	29.4
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	1,603.5	1,900.3	2,094.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	2.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	47,529.4	57,008.5	62,823.5

	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	60.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,351.9	2,850.4	2,931.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.0	3.0	2.8

2 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

*Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Олон улсын валютын сангийн тоон мэдээллээр дэлхийн улс орнууд эдийн засгаа тэлэх, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төсвийн тусгай шаардлага, дүрмийг баримталж байна. Дэлхий нийтэд 106 улс төсвийн дүрэм буюу хязгаарлалтыг хэрэгжүүлж байгаагаас 5 улс 4 төрлийн дүрмийг зэрэг хэрэгжүүлж байна. Тус мэдээллээс харахад 1985 оноос хойш 30 гаран төрлийн төсвийн зарлагын дүрмийг улс орнууд ашиглаж байсан бөгөөд хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй дүрэм нь төсвийн тэнцэл болон өрийн дүрэм байжээ. Үүнээс хөгжиж буй улс орны хувьд төсвийн зарлагын хязгаарын дүрмийг хэрэгжүүлэхдээ ихэвчлэн дотоодын нийт бүтээгдэхүүн эзлэх харьцаа болон орлогын өсөлтийн хувьтай уялдуулдаг байна.

Түүнчлэн төсвийн зарлагын дүрмийг тогтоохдоо нийт зардлаас зарим үзүүлэлтийг хасаж тооцдог улс орнууд байна. Тухайлбал:

- Хүүгийн төлбөрийг хасаж тооцдог улс: Финланд, Франц, Япон, Испани;
- Мөчлөгийн мэдрэмжтэй зардал буюу цаг үеийн онцгой нөхцөл байдалтай холбоотой гэнэтийн зардлыг хасаж тооцдог улс: Финланд, Польш, Испани, АНУ;
- Хөрөнгө оруулалтын зардлыг хасаж тооцдог улс: Хорват, Эквадор, Перу, Их Британи, Сингапур;
- Батлан хамгаалах, аюулгүй байдалтай холбоотой зардлыг хасаж тооцдог улс: Израйл, Перу зэрэг улс байна.

Нийт зарлагаас тодорхой үзүүлэлтүүдийг хасаж, улмаар суурь тэнцлийг тооцох нь дараах ач холбогдолтой байдаг. Үүнд:

- Төсвийн байдлыг бодитой үнэлэх: Суурь тэнцэл нь өнгөрсөн хугацаанд авсан зээлийн хүүгийн нөлөөг оруулахгүйгээр Засгийн газар төсвийн орлогоор үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж чадаж байгаа эсэхийг харуулдаг;
- Мөчлөг дагасан төсвийн бодлогоос сэргийлэх: Эдийн засгийн уналтын үед хүүгийн төлбөр нэмэгдсэний улмаас Засгийн газар зардлаа танах, татвар нэмэх дарамттай тулгарч болзошгүй;
- Өрийн тогтвортой байдлыг хангах: Суурь тэнцэл тэнцвэртэй, ашигтай гарснаар урт хугацаанд өрийн хэмжээг бууруулж, тогтвортой байдлыг хангах боломж бүрдэнэ;
- Нэг удаагийн шинжтэй, онцгой арга хэмжээний зардал нь төсвийн байнгын үйл ажиллагааг тусгадаггүй тул суурь тэнцлийн тооцооллоос хасаж тооцсоноор төсвийн бодлогын төлөв байдлыг илүү бодитой харуулдаг.

Зарим улс эдийн засгаа тэлж, хөгжилд нэн тэргүүнд шаардлагатай төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор зарлагын дүрмийг хэрэгжүүлэхээ зогсоосон байна. Тухайлбал, Канад улс зарлагын хязгаарын дүрмийг 1998-2005 онд хэрэгжүүлсэн бөгөөд 2006 онд зогсоосон, Гүрж улс 2013-2018 онд хэрэгжүүлсэн бөгөөд 2019 онд зогсоосон, Исланд улс 2004-2008 онд хэрэгжүүлсэн бөгөөд 2009 онд зогсоосон, Япон улс 2006 оноос хэрэгжүүлсэн бөгөөд 2009, 2013, 2014, 2019-2021 онуудад зогсоосон, Их Британи улс 2012-2019 онд хэрэгжүүлсэн бөгөөд 2020 онд зогсоосон.

Олон улсын валютын сангийн тоон мэдээллээр төсвийн тусгай шаардлагуудын нэг болох өрийн хязгаарыг дэлхийн 72 улс оронд хүчин төгөлдөр мөрдөж байгаагаас 65 улс нь нэрлэсэн үлдэгдлээр Засгийн газрын өрийг тооцож, дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаанд хязгаар тогтоодог бол өнөөгийн үнэ цэнээр зөвхөн 7 улс тогтоож байна. Эдгээр 7 улсын нэг нь Монгол улс бөгөөд бусад улс нь Африк тивийн Бурунди, Кени, Руанда, Өмнөд Судан, Танзани, Уганда зэрэг В- зээлжих зэрэглэлтэй, дунд буюу бага орлоготой, олон улсын байгууллагуудаас дэмжлэг үзүүлэн санал болгосон нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжилтийн хэрэгцээгээ түлхүү нөхдөг улсууд байна.

Монгол Улсын хувьд 1991 онд ОУВС-д гишүүнээс элсэн орохдоо бага орлоготой улс байсан бол 2011 оноос дундаж орлоготой улсад хамаарагдах болж, зөвхөн нэн хөнгөлөлттэй зээл бус олон улсын зах зээлд гадаад үнэт цаас, баталгаа гаргах, хоёр талт түншүүдээс арилжааны зээл авах зэрэг олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах боломжтой болсон. Мөн дундаж орлоготой орон руу шилжсэнээс шалтгаалан ОУВС, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон бусад хөгжлийн түнш байгууллагуудаас авах гадаад зээлийн эх үүсвэр нь нэн хөнгөлөлттэй нөхцөлөөс аажим шилжиж хөнгөлөлттэй зээл, арилжааны зээлийн хосолсон нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийн төрлийг түлхүү санал болгож байна.

Нэгдсэн төсвийн зарлага, төсвийн тэнцэл, Засгийн газрын өрийн тусгай шаардлагын бүтэц, агуулгыг шинэчилж олон улсын жишигт нийцүүлэх өөрчлөлтийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд тусгалаа. Үүний үр дүнд нэгдсэн төсвийн суурь зарлагын бүтэцэд нийт зарлагаас үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг хасаж тооцсон дүнг хамруулж гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, мөн үүнтэй зэрэгцээд төсвийн суурь тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 ба түүнээс дээш хувийн ашигтай байлгаж энэхүү ашгаар Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулан, улмаар төсөвт учруулах төлбөрийн ачааллыг бууруулах боломж бүрдэнэ. Мөн Засгийн газрын өрийн хязгаарыг өнөөгийн үнэ цэнээр тооцдог байсныг нэрлэсэн үнэ цэнээр тооцдог болсноор Засгийн газрын өрийн бүртгэл олон улсын жишигт нийцэх болно.

Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг дээрх нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан өөрчлөн найрууллаа.

--o0o--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.12, 4.1.13 дахь заалт:

“4.1.12.“нэгдсэн төсвийн суурь зарлага” гэж нийт зарлагаас үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг хасаж тооцсон дүнг;

4.1.13.“нэгдсэн төсвийн суурь тэнцэл” гэж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос суурь зарлагыг хассан дүнг.”

2/6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг:

“6.6.Энэ хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцлийн ашгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна.”

2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалт:

“6.1.2.нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх;

6.1.3.нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх;”

2/12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг:

“12.1.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах үзүүлэлтийг тусгана:

12.1.1.дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ;

12.1.2.хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;

12.1.3.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ;

- 12.1.4.нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ;
- 12.1.5.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл;
- 12.1.6.нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ;
- 12.1.7.нэгдсэн төсвийн суурь тэнцэл;
- 12.1.8.Засгийн газрын өрийн нийт хэмжээ;
- 12.1.9.Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ.”

3 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “өнөөгийн үнэ цэнээр” гэснийг “нэрлэсэн дүнгээр” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Танилцуулга

Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Дэлхийн улс орнууд Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор авч хэрэгжүүлдэг түгээмэл арга замуудын нэг нь өрийн хязгаарыг хуульчлан тогтоох асуудал юм. Олон улсын валютын сан (ОУВС)-гийн тоон мэдээллээр төсвийн тусгай шаардлагуудын нэг болох өрийн хязгаарыг дэлхийн 72 улс оронд хүчин төгөлдөр мөрдөж байгаагаас 65 улс нь нэрлэсэн үлдэгдлээр Засгийн газрын өрийг тооцож, дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаанд хязгаар тогтоодог бол өнөөгийн үнэ цэний аргачлалыг зөвхөн 7 улс ашиглаж байна. Эдгээр 7 улсын нэг нь Монгол улс бөгөөд бусад улс нь Африк тивийн Бурунди, Кени, Руанда, Өмнөд Судан, Танзани, Уганда зэрэг дунд буюу бага орлоготой, олон улсын байгууллагуудаас дэмжлэг үзүүлэн санал болгосон нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжилтийн хэрэгцээгээ түлхүү нөхдөг улсууд байна.

Нэн хөнгөлөлттэй зээл нь хүү маш бага, эргэн төлөгдөх хугацаа урт буюу 30-40 жил байдаг учир ОУВС-аас тухайн зээлийн авах үед нэрлэсэн дүнгээс багаар буюу өнөөгийн үнэ цэнээр тооцон бүртгэж, өрийн тогтвортой байдлыг шинжлэх аргачлалыг бага орлоготой орнууд дээр хэрэглэдэг. Өнөөгийн үнэ цэнээр Засгийн газрын өрийг тооцдог аргачлалыг хэрэгжүүлдэг дээрх орнууд нь гол төлөв өрийн дарамтад орсон, төсвийн алдагдал, санхүүжилтийн хэрэгцээгээ голчлон олон улсын байгууллага, түнш орны нэн хөнгөлөлттэй зээл авч нөхдөг улс орнууд юм. Тухайлбал, Бурунди, Руанда, Танзани, Уганда, Өмнөд Судан зэрэг улсууд нь Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн ННЦ (Highly indebted poor countries) буюу өрийн дарамтад орсон улсуудын тоонд багтдаг.

Монгол Улсын хувьд 1991 онд ОУВС-д гишүүнээс элсэн ороходоо бага орлоготой орны ангилалд хамаарч байсан бөгөөд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад донор орнуудаас нэн хөнгөлөлттэй зээл, тусламжийг ихээр авч ашиглаж байсан тул Засгийн газрын өрийг зөвхөн гадаадын хөнгөлөлттэй зээл бүрдүүлж байсан. Монгол Улс 2011 оноос дундаж орлоготой улсад хамаарагдах болж, зөвхөн нэн хөнгөлөлттэй зээл бус олон улсын зах зээлд гадаад үнэт цаас, баталгаа гаргах, хоёр талт түншүүдээс арилжааны зээл авах зэрэг олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах боломжтой болсон. Мөн дундаж орлоготой орны ангилал руу шилжсэнээс шалтгаалан ОУВС, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон бусад хөгжлийн түнш байгууллагуудаас олгох зээлийн нөхцөл нь нэн хөнгөлөлттэй нөхцөлөөс хөнгөлөлттэй болон арилжааны зээлийн хосолсон нөхцөл рүү шилжээд байна.

Иймд Засгийн газрын өрийн хязгаарыг өнөөгийн үнэ цэнээр бус нэрлэсэн дүнгээр тооцон бүртгэж байхаар хуулийн төслийг боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “өнөөгийн үнэ цэнээр” гэснийг “нэрлэсэн дүнгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг